



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/443


Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн "Тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн батлах тухай" А/619 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222221

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08
дугаар сарын 31 - ны өдрийн
дугаар тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Орлогч дарга	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Төрийн захиргааны удирдлагын газар, Хуулийн хэлтсийн дарга Бодлого төлөвлөлтийн газар, Стратеги, удирдлагын хэлтсийн дарга Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар, Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн дарга Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны газрын ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/ Нийслэлийн эрүүл мэндийн газрын Захиргаа төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/ Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо /ТУЗ-ийн гишүүн/